

"ХОРИХ АНГИД ЯЛ ЭДЭЛЖ БУЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН БАЙДАЛ" СУДАЛГААНЫ ҮР ДҮН

ABOUT RESEARCH IT IS HOW FEMALE INMATES
IN THE WOMEN'S PRISON HAVE BEEN VIOLATED

Т.САРАНЦЭЦЭГ

АШУИҮС, АУС, Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхимийн магистрант, СЭМҮТ,
Поликлиникийн үзлэгийн эмч

SARANTSETSEG T.

Mental health department, SOM, MNUMS, doctor of ambulatory at NCFMH

З.ХИШИГСҮРЭН

АШУИҮС, АУС, Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор,
зөвлөх эмч

KNISHIGSUREN Z.

Ph.D, Assistant professor, consultant, Head of Mental health department

Товч агуулга: Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь нөгөөгөө буюу бусдыгаа үг хэлээр хийгээд биеийн хүчээр дарамталж бие махбодыг бэртээж гэмтээх, шарх сорвитой болгох, хүсээгүй зүйлийг нь албадан хийлгэх, оюун санааны болон сэтгэл зүйн хямралд оруулахыг гэр бүлийн доторх хүчирхийлэл гэдэг. Гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн, үл хайхрах зэрэг хэлбэртэй байдаг¹. НҮБ-ын судалгаагаар эмэгтэйчүүдийн 70% нь амьдралынхаа явцад ямар нэг төрлийн хүчирхийлэлд өртөж байгааг тогтоожээ. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн мэдээгээр Монгол Улсад 3 эмэгтэй тутмын нэг нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болж байна². НҮБ-ын нэгдсэн чуулганы илтгэлүүдээс үзвэл эмэгтэй хоригдлуудын тоо жилээс жилд ихсэж байгаа бөгөөд гэмт хэрэг гарахад хүчирхийлэл, дарамт шахалт, хууль бус үр хөндөлт, хар тамхины хэрэг зэрэг шалтгаан нэмэгдэж байна гэж үзжээ³. Манай улсад судлаач Р.Оюунбадам "Эмэгтэйчүүдийн хорих ял, онол, арга зүй, практик" сэдвээр 2013 онд доктор⁴, Ж.Батдолгор "Эмэгтэйчүүдийн гэмт явдлын шалтгаан нөхцөл" сэдвээр 2002 онд магистрын зэрэг хамгаалсан байна⁵. Монгол Улсад одоогоор хорих ангид ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хүчирхийлэлд өртсөн байдлыг судалсан судалгаа байхгүй байгаа учир бид энэхүү судалгааг хийх үндэслэл болсон юм.

Abstract: Domestic violence is a pattern of behavior which involves verbal or physical abuse by one person against another in a domestic setting, and make them mentally and emotionally distressed. Domestic violence is classified as physical, emotional, sexual, financial and neglecting¹. According to a study of UNICEF, 70% of women face with a violence in their lifetime. The news of National Anti-Violence center reports that 1 out of 3 women are become victim of domestic violence in Mongolia.² Due to reports of UNICEF the number of female inmates is increasing yearly and violence, distress, illegal abortion and drug use are the main cause of it.³ Oyunbadam.R (2013) et al defended doctor degree under the study called "Mongolian women imprisonment, theory, methodology and practice."⁴ Batdolgor.J defended master degree in 2002 by the topic called "Etiology of women crime".⁵ In Mongolia, there is no study about violence towards female inmates, So we aimed to study about it.

Түлхүүр үгс: Эмэгтэйчүүд, хорих анги, хүчирхийлэл, гэр бүл.

Key words: Women, family, violence, prison.

¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль. УБ., 2014.

² Хүний эрхийг хамгаалагч байгууллага. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн тухай. Хүний эрхийн тайлан. УБ., 2014.

³ Организация Объединенных Наций. Генеральная Ассамблея. 2013.

⁴ Р.Оюунбадам. "Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн хорих ял, онол, арга зүй, практик" сэдэвт докторын диссертаци. УБ., 2013.

⁵ Ж. Батдолгор. "Эмэгтэйчүүдийн гэмт явдлын шалтгаан нөхцөл" магистрын дипломын ажил. УБ., 2002.



ХҮҮЛЬ САХИУЛАХУЙ

Зорилт:

1.Хорих ангид ял эдэлж буй эмэгтэйчүүдийн ял эдлэхээс өмнө хүчирхийлэлд өртсөн байдлыг судалж тогтоох;

2.Хорих ангид ял эдэлж буй эмэгтэйчүүдийн бие махбодын хүчирхийллийн улмаас үүссэн эрүүл мэндийн хохирлыг судалж тогтоон, судлаачийн зүгээс дүгнэлт хийх.

Судалгааны арга зүй:


Судалгааг эмэгтэйчүүдийн хорих 407 дугаар ангийг түшиглэн, агшингийн судалгааны загвараар, зорилтот түүврийн аргаар, чанга дэглэмд ял эдэлж буй 60 эмэгтэйчүүдэд тусгайлан боловсруулсан карт ашиглан асуумж судалгааны аргаар явуулсан. Ёс зүйн зөвшөөрлийг зохих журмын дагуу авсан болно.

Судалгааны үр дүн:

Бидний судалгаанд хорих 407 дугаар ангийн чанга дэглэмд ял эдэлж буй нийт 24-65 насны 60 эмэгтэйчүүд хамрагдсан. Дундаж нас 40.5 байсан бөгөөд насны бүлгээр 46-аас дээш насны эмэгтэйчүүд 26.7% (n=46) хамгийн их хувийг эзэлж байв. Орон нутгийн харьяаллаар авч үзвэл Улаанбаатар хотынх 73.3% (n=44), хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд 39.1% (n=16) байсан юм. Нийгмийн байдлыг судлан үзэхэд ихэвчлэн дээд боловсролтой 43.3% (n=26) эмэгтэйчүүд хамгийн их байсан бол тусгай дунд боловсролтой хамгийн бага байв.

Зураг 1. Гэр бүлийн байдал /хувиар/

Нэгдүгээр зургаас үзвэл, гэр бүлтэй, салсан хамгийн их хувийг буюу тус бүр 28.3% (n=17) байсан бол хамтран амьдрагчтай, ганц бие хүмүүс хамгийн бага




байлаа. Судалгаанд хамрагдагчдын хүүхдийн байдлыг судалж үзвэл хүүхэдтэй 85% (n=51) эмэгтэйчүүд, харин эмэгтэйчүүдийн 15% (n=9) нь хүүхэдгүй байсан. Тухайн гэр бүлд хүчирхийлэл байсан эсэхийг судлахад 25% (n=15) ямар нэгэн хүчирхийлэлд өртөж байсан гэжээ.

Хүснэгт 1. Хүчирхийллийн хэлбэрүүдийг судлан үзвэл:

№	Хүчирхийллийн хэлбэр	Хувь	Тоо
1.	Бэлгийн хүчирхийлэл	10.0%	6
2.	Бие махбодын хүчирхийлэл	21.7%	13
3.	Сэтгэл санааны хүчирхийлэл	21.7%	13
4.	Эдийн засгийн хүчирхийлэл	6.7%	4
5.	Үл хайхрах хүчирхийлэл	5.0%	3

Нэгдүгээр хүснэгтээс үзвэл давхардсан тоогоор бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэл өндөр гарсан. Харин хэн хүчирхийлэл үйлддэг болохыг судлан үзэхэд нөхөр 18.3% (n=11), хойд эцэг 6.7% (n=4), хамаатан садан, ах нар 8.3% (n=5) үйлддэг байсан бөгөөд нөхөр нь хүчирхийлэл үйлдэх нь илүүтэй байна.

Зураг 2. Бие махбодын хүчирхийллийн улмаас үүссэн гэмтлийн хэлбэрүүд:



Хоёрдугаар зургаас үзвэл зөөлөн эдийн болон тархины гэмтэл хамгийн их хувийг эзэлж байв. Харин хүчирхийллээс болж хэн нэгэнд хандаж байсан эсэхийг судлахад 81.7% (n=49) эмэгтэйчүүд хэнд ч хандаж байгаагүй гэж хариулсан. Тухайн эмэгтэйчүүдийн гэр бүлийн харьцааг судлахад өв тэгш 45% (n=27), өв тэгш бус 5% (n=3), хэн нэгний эрхшээлд 6.7% (n=4), дотоод харилцаа алдагдсан 15% (n=9), салж сарнисан 5% (n=3), салж сарниж байгаа 16.7% (n=10), хуурамч эв түнжинтэй амьдарч байсан 6.7% (n=4) гэр бүл байв. Судалгаанд хамрагдагчдын хорт зуршлын анамнезаас үзвэл, ял эдлэхээс өмнө архи хэрэглэж байсан 30% (n=18), тамхи хэрэглэдэг байсан 28.3% (n=17), харин одоо тамхи хэрэглэж байгаа 33.3% (n=20) эмэгтэйчүүд байсан бөгөөд тамхи хэрэглэж байгаа шалтгаанаа гэр бүлийн зөрчил, бухимдлаа тайлах зорилгоор хэрэглэж байгаа гэж хариулсан. Харин эцэг, эх нь архи хэрэглэдэг 21.7% (n=13), тамхи хэрэглэдэг 40% (n=24), гэмт хэрэгт холбогдож байсан. Тухайн хорих ангид анх ял эдэлж байгаа 86.7% (n=52) харин давтан ял эдэлж байгаа 13.3% (n=8) байв. Үүнээс, үзвэл давтан ял эдэлж байгаа эмэгтэйчүүд цөөнгүй байна.

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдагчийн үйлдсэн гэмт хэргийн төрөл:

№	Гэмт хэргийн төрөл	Хувь	Тоо
1.	91-р зүйл анги. Хүнийг санаатай алах	50%	30
2.	96-р зүйл анги. Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах	1.7%	1
3.	145-р зүйл анги. Бусдын эд хөрөнгийг хулгайлах	3.3%	2
4.	148-р зүйл анги. Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах	35%	21
5.	188-р зүйл анги. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх	5%	3
6.	192-р зүйл анги. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах	5%	3

Хоёрдугаар хүснэгтээс үзвэл Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлд заасан "хүнийг санаатай алах" гэмт хэрэг хамгийн их хувийг эзэлсэн байсан уг хэргийг үйлдэх болсон шалтгаанаа тухайн үед хүчирхийллээс үүдэлтэй биеэ хамгаалж хийсэн гэж хариулав.



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХ
УНИВЕРСИТЕТ

ДҮГНЭЛТ

1.Хорих 407 дугаар ангийн чанга дэглэмд ял эдэлж буй эмэгтэйчүүдийн 25% нь ямар нэгэн хүчирхийлэлд өртөж байсан.

2.Хүчирхийллийн хэлбэрийг судалж үзвэл, бие махбодын, сэтгэл санааны хүчирхийлэл хамгийн өндөр байна. Хүчирхийллийн улмаас бие махбодын гэмтэл, зөөлөн эдийн гэмтэл 20%, тархины гэмтэл 15% байв.

ХЭЛЦЭМЖ

АНУ-н Shaunon M. Lynch, Dana D. De Hart, Joanne Belknap, Bol. Green нарын судалснаар эмэгтэй хоригдлууд нь мансууруулах бодист донтох эмгэг, эмэгтэйчүүд биеийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан байна¹.

Бидний судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн 25% (n=15) нь ямар нэг хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн байв. Тиймээс бид хорих ангид ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хүчирхийлэлд өртсөн байдлыг судалсан бөгөөд түүнийг хэрхэн даван туулах болон урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл олгох зайлшгүй шаардлагатай байгаа юм. Дэлхийн ихэнх оронд эцгийн эрхт ёс ноёрхож байгаатай холбоотой хүчирхийлэл, ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийн хүчирхийлэл оршин байсаар байна².

Хүн амын олонх нь хүчирхийлэлтэй холбоотой гэмт явдал хүнд ямар хор уршигтайг бүрэн ухамсарладаггүй. Хүчирхийлэл нь гадны шалтгаант нас баралт Монгол Улсын хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаанд орж байгааг анхаарч Засгийн газрын зүгээс дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна³.

Doris J. James and Lauren E. Glaze нарын судалснаар ял эдэлж

буй эмэгтэйчүүдийн эцэг эх, асран хамгаалагч нарын 39% нь архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэдэг байсан гэсэн үр дүн гарсан бол бидний судалгаанд эцэг, эх нь архи хэрэглэдэг 21.7% (n=13), тамхи хэрэглэдэг 40.% (n=24), харин эцэг эхийн аль нэг нь гэмт хэрэгт холбогдож байсан 5%(n=3) гарсан нь харьцангуй ялгаатай гарсан байв⁴.

Талархал: Энэхүү судалгааны ажлыг хийхэд гүн туслалцаа үзүүлсэн эмч Л.Цэрэндолгор, ШШГЕГ-н харьяа Хорих 407 дугаар ангийн хамт, сэтгэл зүйч, дэслэгч Э.Уянга нартаа баярласнаа илэрхийлье.

¹ Shaunon M. Lynch, Ph.D. Dana D. De Hart, Ph.D. Joanne Belknap, Ph.D. Bol. Green Ph.D. Women's Pathways to Jail: Examining Mental Health, Trauma and Substance Use.

² Д.Одонтуяа. Монгол Улсад гэр бүлийн хүчирхийллийн талаар асуумж авч судалсан байдал. Онош. 2002. №1(013). Х1-4

³ ЭМЯ. ДЭМБ. "Гэр бүл. Жендерт суурилсан хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийллийн өнөөгийн байдал, бууруулах арга зам" сэдэвт салбар дундын зөвлөлдөх уулзалт. УБ., 2007.

⁴ Doris J. James and Lauren E. Glaze. Mental Health Problems of Prison and Jail Inmates. 2006.